

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/110/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Болд Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: Bat-Erdenes@audit.gov.mn Аудитор: Г.Мөнхчимэг Утас: 261628 Цахим хаяг: Munkhchimegg@audit.gov.mn Аудитор: П.Ариунзаяа Утас: 261628 Цахим хаяг: Aruinzayap@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨӨ АЖ АХУЙН КОРПОРАЦИ
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЦОГТСАРАН ТАНАА

2024.03.15

№

07/733

танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн дараах зөрчлүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархсан байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар улсын төсөвт 47,455.8 сая төгрөгийн дамжуулан зээлийн эргэн төлөх үндсэн төлбөрөөс 19,054.1 сая төгрөгийг төвлөрүүлээгүй;
- Санхүүгийн тайлангаарх нийт авлагын 59.0 хувь буюу 101,836.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Мал хамгаалах сангаас /хуучнаар / 5 нэр төрлийн 78 ширхэг нийт 2,570.2 сая төгрөгийн дансны үнэ бүхий малын тэжээлийн үйлдвэр, хадлангийн иж бүрдэл, өвс хаман боогч зэрэг техник, тоног төхөөрөмжийг иргэн хуулийн этгээдэд түрээсийн гэрээгээр 7 жилийн хугацаатай эзэмшүүлж, ашиглуулж байгаа боловч, гэрээг дүгнээгүй, тооцоо хийгээгүй, түрээслэгчээс тоног төхөөрөмжийг хүлээн аваагүй;
- "ХААК" ТӨХХК нь "Д" ХХК-тай 2023 оны ӨТБГ-23/01 дугаартай "Санхүүгийн түрээсийн өр төлбөр барагдуулах гэрээ"-г байгуулж, гэрээгээр 42,422.2 сая төгрөгийг тайлант оны эцэст бүрэн төлж барагдуулах үүргийг хүлээсэн боловч гэрээний хэрэгжилт хангалтгүй 31,853.0 сая төгрөгийн төлбөрийн үлдэгдэлтэй;
- БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Сангийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны /тухайн үеийн/ хооронд 2013 онд байгуулсан "Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах" төсөл болон Газар тариалангийн зориулалттай зарим

Z:\Yawsan_Bichigl\2024\0325 SNAG-60.Docx

0001051102

техник, тоног төхөөрөмж худалдан авах төсөл"-ийн дамжуулан зээлийн нийт 107,699.2 сая төгрөгийн үлдэгдлийг жилийн 6 хувийн хүүтэйгээр, 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд төлж барагдуулах үүргийг хүлээсэн боловч тайлант оны эцэст нийт 117,901.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн үлдэгдэлтэй;

- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллагаагүй зэрэг нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Өрийн удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.1, 31.2.4, 31.2.5, 32 дугаар зүйлийн 32.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 49 дүгээр тушаалын 2, Сангийн сайд, ХХААХҮС хооронд байгуулсан 2020 оны "Дамжуулан зээлдүүлэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ"-ний 3, "Д" ХХК-тай 2023 онд байгуулсан "Санхүүгийн түрээсийн өр төлбөр барагдуулах тухай" ӨТБГ-23/01 дугаартай гэрээний 3.2.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй, Санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1	Эргэлтийн хөрөнгө		262,339,694,404.32
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө		2,862,025,240.45
1.1.2	Дансны авлага		20,469,713,068.47
1.1.4	Бусад авлага		173,780,614,293.00
1.1.6	Бараа материал		5,141,982,601.92
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		60,085,359,200.48
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн		262,339,694,404.32
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		80,099,930,923.19
1.2.1	Үндсэн хөрөнгө		80,099,930,923.19
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		80,099,930,923.19
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		342,439,625,327.51
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		342,439,625,327.51
2.1	ӨР ТӨЛБӨР		270,370,284,102.16
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		96,369,685,045.72
2.1.1.2	Цалингийн өглөг		1,996,659.10
2.1.1.3	Татварын өр		136,665,034.78
2.1.1.4	НДШ-ийн өглөг		351,440.24
2.1.1.5	Богино хугацаат зээл		463,334,571.90
2.1.1.6	Хүүгийн өглөг		18,305,466,841.88
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		436,309,349.77
2.1.1.12	Бусад богино хугацаат өр төлбөр		77,025,561,148.05
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		174,000,599,056.44
2.1.2.1	Урт хугацаат зээл		174,000,599,056.44
2.2	Өр төлбөрийн нийт дүн		72,069,341,225.35
2.3	Эздийн өмч		81,130,221,166.51
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		13,162,475,821.95
2.3.9	Хуримтлагдсан ашиг		-22,223,355,763.11
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		342,439,625,327.51

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)		12,200,347,946.99
2	Борлуулалтын өртөг		11,014,641,682.10
3	Нийт ашиг (алдагдал)		1,185,706,264.89
4	Түрээсийн орлого		765,152,064.20
5	Хүүгийн орлого		741,587,770.78
6	Торгууль орлого алданги		802,156,008.67
8	Бусад орлого		117,358,242,280.28
9	Борлуулалт, маркетингийн зардал		3,183,920,074.69
10	Ерөнхий ба удирдлагын зардал		3,440,989,438.17
11	Санхүүгийн зардал		3,491,882,927.01
12	Бусад зардал		2,500,000,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		5,773,283,394.79
17	Бусад ашиг (алдагдал)		987,072,799.60
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		101,475,695,754.56
19	Орлогын татварын зардал		0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)		101,475,695,754.56
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		101,475,695,754.56
24	Орлогын нийт дүн		101,475,695,754.56
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
5	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	-
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	81,130,221,166.51	13,162,475,821.95	-123,699,051,517.67	-29,406,354,529.21
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
13	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
14	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	101,475,695,754.56	101,475,695,754.56
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	81,130,221,166.51	13,162,475,821.95	-22,223,355,763.11	72,069,341,225.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант үеийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		34,919,323,596.63
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого		21,183,194,503.26
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		316,902,128.78
1.1.6	Бусад мөнгөн орлого		13,419,226,964.59
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)		31,986,462,156.18
1.2.1	Ажилагсад төлсөн		1,747,414,442.96
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		523,032,517.16
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		82,966,627.60
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		231,447,688.67
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		61,334,130.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		86,420,519.95
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		-
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		488,460.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага		29,253,357,769.84
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		2,932,861,440.45
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		70,836,200.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		70,836,200.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		2,862,025,240.45
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,862,025,240.45

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

СНАГ-2024/110/НА-СТА-ТӨА

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны 08 сарын 24-ний өдөр батлагдсан төсөв	Тодотгол хийсэн нийт төсөв	2023 оны биелэлт ХААК	Хэтрэлт хэмнэлт	
1	НИЙТ ОРЛОГО	мян.төг	5,585,091.0	5,585,091.0	10,527,147.6	4,942,056.6	
	1.1.	Үндсэн үйл ажиллагааны орлого	мян.төг	2,218,500.0	2,218,500.0	9,315,615.8	7,097,115.8
	1.1.1	Үр тарианы	мян.төг	2,218,500.0	2,218,500.0	9,315,615.8	7,097,115.8
	1.2.	Туслах үйл ажиллагааны орлого	мян.төг	3,366,591.0	3,366,591.0	1,211,531.8	(2,155,059.2)
2	НИЙТ ЗАРДАЛ	мян.төг	9,036,022.3	8,376,055.5	15,337,552.4	6,961,496.9	
	2.1.	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	мян.төг	1,789,900.0	1,884,650.0	1,747,414.4	(137,235.6)
	2.2.	Нийгмийн даатгалын шимтгэл	мян.төг	223,737.5	362,723.3	523,032.5	160,309.2
	2.3.	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	мян.төг	215,044.6	209,687.4	231,447.7	21,760.3
	2.4.	Хангамж, бараа материалын зардал	мян.төг	1,393,091.0	805,533.9	144,300.8	(661,233.2)
	2.5.	Нормативт зардал	мян.төг	-	-	-	-
	2.6.	Эд хогшил, урсгал засварын зардал	мян.төг	663,000.0	706,772.0	386,137.4	(320,634.6)
	2.7.	Томилолт, зочны зардал	мян.төг	224,820.9	262,949.9	188,812.8	(74,137.0)
	2.8.	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	мян.төг	3,242,815.4	2,798,902.3	10,510,231.8	7,711,329.5
	2.10.	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	мян.төг	69,276.9	130,500.8	95,762.5	(34,738.3)
	2.11.	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	мян.төг	1,214,335.9	1,214,335.9	1,510,412.5	296,076.6
		Татварын өмнөх ашиг, алдагдал	мян.төг	(3,450,931.3)	(2,790,964.5)	(4,810,404.8)	(2,019,440.3)
3	3.1.	БАЙГУУЛЛАГЫН ТОО	тоо	8	8	8	-
4	4.1.	АЖИЛЛАГСДЫН ТОО	тоо	148	148	148	-
	4.2.	Үндсэн цалингийн сан	мян.төг	1,552,500.0	1,637,080.0	1,635,611.5	(1,468.5)
	4.3.	Ажилтны дундаж сарын цалин	мян.төг	1,907.2	2,011.2	2,009.4	(1.8)
5	Улаанбуудайн нөөц бүрдүүлэлт	тонн	60,200.0	60,200.0	44,135.53	(16,064.47)	
	5.1.	Хүнсний улаанбуудай	тонн	55,200.0	55,200.0	28,775.41	(26,424.59)
	5.1.1.	-Өрөнд	тонн	33,600.0	33,600.0	8,908.60	(24,691.40)
	5.1.2.	-Худалдан авах	тонн	21,600.0	21,600.0	19,866.81	(1,733.19)
	5.2.	Үрийн буудай	тонн	5,000.0	5,000.0	4,778.31	(221.69)
	5.2.1.	-Өрөнд	тонн	3,300.0	3,300.0	385.01	(2,914.99)
	5.2.2.	-Худалдан авах	тонн	1,700.0	1,700.0	4,393.30	2,693.30
	5.3.	Тэжээлийн буудай	тонн	-	-	10,581.81	10,581.81
5.3.1.	-Өрөнд	тонн	-	-	10,581.81	10,581.81	
6	Авлага барагдуулалт	мян.төг	44,536,800.0	44,536,800.0	29,993,904.3	(14,542,895.7)	
	6.1.	Хүнсний буудай	мян.төг	31,248,000.0	31,248,000.0	9,060,999.3	(22,187,000.7)
	6.2.	Үрийн буудай	мян.төг	4,620,000.0	4,620,000.0	586,410.2	(4,033,589.8)
	6.3.	Тэжээлийн буудай	мян.төг	-	-	6,864,815.6	6,864,815.6
7	Эргэн төвлөрүүлэх зээл	мян.төг	16,975,782.7	16,975,782.7	18,088,486.1	(2,487,569.5)	
	7.1.	Ди Би Эм Лизинг ХХК-ний зээл	мян.төг	11,704,328.0	11,704,328.0	13,000,000.0	1,295,672.0
	7.2.	БНБеарусь Улсын зээл	мян.төг	1,576,491.9	1,576,491.9	1,488,213.2	(88,278.6)
	7.3.	БНХАУ-ын Засгийн газрын зээл	мян.төг	500,000.0	500,000.0	3,000.0	(497,000.0)
	7.4.	Мал хамгаалах сан	мян.төг	3,194,962.8	3,194,962.8	3,597,272.8	402,310.0
8	Хөрөнгө оруулалт	мян.төг	101,100.0	289,783.4	70,836.2	(218,947.2)	
	8.1.	Техник, тоног төхөөрөмж	мян.төг	61,100.0	161,100.0	70,836.2	(90,263.8)
	8.2.	Барилга байгууламж	мян.төг	40,000.0	128,683.4	-	(128,683.4)

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөдөө аж ахуйн бага оврын болон газар тариалангийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмж худалдан авах төслийн санхүүжилтээс Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн улаан буудайн худалдан авалт болон бусад үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж 20,324.5 сая төгрөгийн авлага, өр төлбөр үүссэн байна. Засгийн газрын шийдвэрээр 2020 онд төслийн нэгжийг Хөдөө аж ахуйг дэмжих санд нэгтгэхэд сангаас авах авлага, төслийн нэгжид өгөх өр төлбөрөөр бүртгэгдсэн нь өнөөг хүртэл хэвээр байгааг санхүүгийн тайланд залруулах арга хэмжээ аваагүй байна.	1	20,324,547.8			1	20,324,547.8			1	20,324,547.8	1	20,324,547.8
Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Хан-Уул дүүргийн ИХАШШ-ийн 183/ШШ2023/01220 дугаартай шийдвэрээр тогтоогдсон 1 ажилтанд олгосон 5.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийг буруу шийдвэр гаргасан ажилтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй, санхүүгийн тайланд авлага үүсгээгүй байна.	1	5,824.1	1	5,824.1			1	5,824.1				
ХХААХҮС-ын 2023 оны А/683 дугаар тушаалаар тус компанийн биологийн хөрөнгийн дансанд нийт 857.0 сая төгрөгөөр бүртгэлтэй Суффолк, Романов, Беришон, Душёр, Меринос үүлдрийн 304 толгой хонь, Лимузин үүлдрийн 20 толгой үхрийг Малын удмын сангийн үндэсний төвд балансаас балансад шилжүүлэх шийдвэр гарсныг данс бүртгэлээс хасаагүй байна.	1	856,977.9			1	856,977.9	1	856,977.9				
Дүн	3	21,187,349.8	1	5,824.1	2	21,181,525.7	2	862,802.0	1	20,324,547.8	1	20,324,547.8

3.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд нийт авлагын 59.0 хувь буюу 101,836.1 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	101,836,100.0			1	101,836,100.0		
Мал хамгаалах сангаас /хуучнаар/ 5 нэр төрлийн 78 ширхэг нийт 2,570.2 сая төгрөгийн дансны үнэ бүхий малын тэжээлийн үйлдвэр, хадлангийн иж бүрдэл, өвс хаман боогч зэрэг техник, тоног төхөөрөмжийг иргэн хуулийн этгээдэд түрээсийн гэрээгээр 7 жилийн хугацаатай эзэмшүүлж, ашиглуулж байгаа боловч, гэрээг дүгнээгүй, тооцоог хийгээгүй, түрээслэгчээс тоног төхөөрөмжийг хүлээж аваагүй байна.	1	2,570,217.9			1	2,570,217.9		
"ХААК" ТӨХХК нь "Д" ХХК-тай 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр ӨТБГ-23/01 дугаартай "Санхүүгийн түрээсийн өр төлбөр барагдуулах гэрээ"-г байгуулсан байна. Гэрээгээр СТГ/17-01 дугаартай санхүүгийн түрээсийн гэрээний үлдэгдэл төлбөр болох нийт 6,307,513.20 ам.доллар, СТГ/18/12 санхүүгийн түрээсийн гэрээний үлдэгдэл төлбөр болох нийт 5,473,440.05 еврог гэрээ байгуулах өдрийн Төв банкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн дүн буюу 42,422.2 сая төгрөгийг 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор бүрэн төлж барагдуулах үүргийг хүлээсэн боловч тайланд оны эцэст 31,853.0 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	31,853,034.2			1	31,853,034.2		
БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Сангийн яам Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны /тухайн үеийн/ хооронд 2013 онд байгуулсан "Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах" төсөл, тариалангийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмж худалдан авах төсөл"-ийн хүрээнд тодорхойлсон үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор 40.0 мянган ам.долларын дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулсныг 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Дамжуулан зээлдүүлэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах 58 дугаартай гэрээг шинэчлэн байгуулсан байна. Дээрх гэрээгээр 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөрх 12.1 сая ам.долларын үлдэгдлийг төгрөгт шилжүүлэн, Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төсөл"-ийн дамжуулан зээлийн үлдэгдэл 74,115.0 сая төгрөг, "Газар тариалангийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмж худалдан авах төсөл"-ийн дамжуулан зээлийн үлдэгдэл 33,584.2 сая төгрөг, нийт 107,699.2 сая төгрөгийн үлдэгдлийг жилийн 6 хувийн хүүтэйгээр, 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд төлж барагдуулах үүргийг хүлээсэн боловч 2023 оны жилийн эцсийн байдлаар үндсэн зээлийн 99,621.1 сая төгрөг, хүүгийн төлбөрийн 18,280.5 сая төгрөг, нийт 117,901.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	117,901,655.5			1	117,901,655.5		

2023 оны төсвийн тухай хуулиар улсын төсөвт 47,455.8 сая төгрөгийн дамжуулан зээлийн эргэн төлөх үндсэн төлбөрийг төвлөрүүлэхээс 28,401.4 сая төгрөгийг төвлөрүүлж, 19,054.1 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.	1	19,054,101.7			1	19,054,101.6		
"ХААК" ТӨХХК нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад хүргүүлэхдээ холбогдох хуульд заасан цаглаварт хугацаанаас 11 хоног хугацаа хоцроож хүргүүлсэн, мөн Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгээгүй, Төсөвт байгууллагад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, аргачлалын дагуу бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайлан, тодруулгыг ирүүлсэн.	1	-			1	-		
Тайлант хугацаанд албан хэрэгцээнд нэр бүхий 3 ААН-ээс 77.6 сая төгрөгийн компьютер, принтер, бусад зүйлийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шууд худалдан авсан байна.	1	77,587.9			1	77,587.9		
Тус компани нь санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар аргачлалыг багтаасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллаагүй, санхүүгийн программ хангамжид бүртгэлийн үйл ажиллагааны онцлогт тохируулан сайжруулалт хийлгүүлээгүй байна.	1	-					1	-
Дүн	8	273,292,697.2			7	273,292,697.2	1	-

3.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 167 мэдээлэл байршуулахаас 24 мэдээллийн хугацааг хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.	1	-			1	-		
Дүн	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
“ХААК” ТӨХХК-ийн эзэмшилд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг цэнхэр өнгө бүхий улсын дугаараар солих ажлыг зохион байгуулаагүй байна.	1	-					1	-
Монгол банкны зээлийн мэдээллийн санд 9722 зээлдэгчийн мэдээлэл байршуулахаас 4115 зээлдэгчийн мэдээллийг байршуулаагүй байна.	1	-			1	-		
Өмнөх оны аудитаар өгсөн 3, албан шаардлагыг хугацаанд биелүүлээгүйгээс, зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд: • Авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, зээлийг барагдуулах талаар тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулах, хяналт тавьж ажиллах; • Гадны эх үүсвэртэй дамжуулан болон арилжааны зээлийг эргэн төлөлтийн графиктай уялдуулж, жил бүрийн төсөвт тусгуулах, зээлдэгчийн эргэн төлөлтийг зориулалт бусаар зарцуулахгүй байх; • Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;	1	-			1	-		
Дүн	3	-	-	-	2	-	1	-
Нийт дүн	4	-	-	-	3	-	1	-